



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар A/186

Мандалговь

Сургалтын төлбөрийн дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай 61 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Дундговь аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн 4.2.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Бүгд Найрамдах Солонгос Улсын Нутгийн удирдлагын хөгжлийн институт (LOGODI) -тэй хамтран хэрэгжүүлж байгаа Монгол Улсын нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтаныг чадавхижуулах хөтөлбөрийн хүрээнд хамрагдах аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Н.Эрдэнэ-Очирын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсүгэй.
2. Төлбөрт шаардагдах 1,998,500 (Нэг сая есөн зуун ерэн найман мянга таван зуун) төгрөгийг Орон нутгийн хөрөнгө оруулалт "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат), Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



4823100490